



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Хот байгуулалт, барилга захиалагчийн алба ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ОРА-2024/6/НА-СТА-ОНА

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Орхон аймаг  
2024 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах  
Утас: 70353088 Цахим хаяг: [narmandakhts@audit.gov.mn](mailto:narmandakhts@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Буян-Ундрах  
Утас: 70355805 Цахим хаяг: [buyanundrakhb@audit.gov.mn](mailto:buyanundrakhb@audit.gov.mn)

“Төгс Нотолгоо аудит” ХХК-ийн захирал: Г.Цэцэгмаа  
Утас: 99889665 Цахим хаяг: [tugsnotolgooaudit@gmail.com](mailto:tugsnotolgooaudit@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ОРХОН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,  
Урт булаг баг, Ханддоржийн  
гудамж, Утас/Факс: 70359826  
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2024.08.25 № 75  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ОРХОН АЙМГИЙН ХОТ  
БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА  
ЗАХИАЛАГЧИЙН АЛБА ОНӨААТҮГ-  
ЫН ДАРГА П.БАЯСГАЛАН ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Орхон аймгийн "Хот байгуулалт, барилга захиалагчийн алба" ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Орхон аймгийн "Хот байгуулалт, барилга захиалагчийн алба" ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Үүнд:

1. Албан хаагчдад хоол, унааны нэмэгдэл 59,810.0 мянган төгрөгийг тушаал шийдвэргүй олгосон.
2. Албан хаагчдад ээлжийн амралттай байх хугацаанд 1,091.9 мянган төгрөгийн цалин, албан томилолтоор ажилласан хугацаанд хоол, унааны нэмэгдэл 480.0 мянган төгрөгийг давхардуулан олгосон.
3. Нягтлан бодогч, нярав нарт үндэслэлгүй 2,260.7 мянган төгрөгийн урамшуулал илүү олгосон.
4. Уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулсан гэж нотлох баримтгүйгээр 2,970.0 мянган төгрөг зарцуулсан.
5. Тайлант онд 220.0 мянган төгрөгөөр архи согтууруулах ундаа худалдан авсан.
6. Цагийн бүртгэлээр нотлогдохгүй 4,510.5 мянган төгрөгийн илүү цагийн нэмэгдэл хөлс олгосон.

7. 1 албан хаагчид үндэслэлгүй 5,054.7 мянган төгрөгийн орон нутгийн нэмэгдэл хөлс олгосон.
8. Нягтлан бодогч, эд хариуцагч, мэдээллийн ажилтан, архивч, үйлчлэгч нарт үндэслэлгүй 720.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон.
9. Жолоочийн тооцооны замын хуудас бичсэн боловч автомашины 100 км-т зарцуулах нормативаар шатахууны тооцоог бодоогүй 1,777.4 мянган төгрөгийн шатахууныг илүү зарцуулсан.
10. Албан хаагчийн хувийн тээврийн хэрэгслээр албан ажил гүйцэтгэн, жолоочийн замын хуудас бичсэн боловч спидометрийн заалтгүй 3,607 километр 1,158.8 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан.
11. Үр дүнгийн урамшуулал 1,800.0 мянган төгрөгийг олгохдоо нийгмийн даатгалын шимтгэл суутгаагүй.
12. Нягтлан бодогч солигдох үед хөрөнгийн тооллого хийгээгүй байна.

Дээрх зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8.1-т “Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна:”, 13.1-т “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7-т “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.”, Хөдөлмөрийн тухай хуулийн 91.1-т “Ажилтныг ажил олгогчийн санаачилгаар ердийн ажлын өдрийн үргэлжлэл, ээлжийн ажлын цаг, долоо хоногийн ажлын цагийн үргэлжлэл болон ажлын цагийг нэгтгэн бодох ердийн ажлын цагийн нийлбэрээс хэтрүүлэн ажиллуулахыг илүү цагаар ажилласанд тооцно.”, 98.1-т “Тасралтгүй ажиллагаатай үйлдвэрлэл, хүн амын нийтлэг үйлчилгээ, тээвэр, холбооны болон зайлшгүй шаардлагатай ажил гүйцэтгүүлэх, энэ хуулийн 91.2-т зааснаас бусад тохиолдолд нийтээр амрах баярын болон долоо хоногийн амралтын өдөр ажилтан өөрөө зөвшөөрснөөс бусад тохиолдолд ажил олгогчийн санаачилгаар ажиллуулахыг хориглоно.” гэж заасантай нийцэхгүй байна.

#### **Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд 1,178,685.3 мянган төгрөгийн орлогын төлөвлөгөөтэй ажилласнаас 1,227,281,9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 42,395.0 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Оны эцэст харилцах данс 263,405.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, 16,990.6 мянган төгрөгийн нэмэгдсэн өртгийн албан татварын, 20,743.8 мянган төгрөгийн хувь хүний болон аж ахуйн нэгжийн орлогын албан татварт авлагатай байна.

#### **Аудитын гол асуудал**

Биет хөрөнгийн дансанд 1,097,733.6 мянган төгрөгийн өртөг бүхий 17 зураг төсөв байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын 21 зорилт, 116 ажил хэрэгжүүлэхээр Орхон аймгийн Засаг даргатай гэрээ байгуулж, гүйцэтгэлийн тайлангийн хэрэгжилт хангалттай дүгнэгдсэн байна.

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй төрийн аудитын албан хаагчид аливаа этгээдийн нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

#### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

		/төгрөгөөр/	
Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	155,410,598.58	292,621,859.38
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	110,058,098.58	263,405,380.73
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	110,058,098.58	263,405,380.73
31210	Төгрөг	110,058,098.58	263,405,380.73
31213	Арилжааны банк дахь харилцах	110,058,098.58	263,405,380.73
33	АВЛАГА	27,009,700.00	20,743,892.65
33402	Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	27,009,700.00	20,743,892.65
35	БАРАА МАТЕРИАЛ	18,342,800.00	8,472,586.00
35100	Түүхий эд материал	5,832,494.00	0.00
35110	Тусгай зориулалттай материал	5,832,494.00	0.00
35400	Хангамжийн материал	12,510,306.00	6,488,176.00
35410	Бичиг хэргийн материал	3,412,010.00	1,984,410.00
35470	Бусад хангамжийн материал	9,098,296.00	0.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,192,055,656.51	1,771,189,740.49
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,192,055,656.51	1,771,189,740.49
39200	Биет хөрөнгө	108,935,857.90	269,601,729.51
39201	Барилга, байгууламж, орон сууц	17,231,943.77	17,231,943.77
39202	Хуримтлагдсан элэгдэл	-4,914,567.59	-5,776,098.60
39203	Авто-тээврийн хэрэгсэл	49,850,000.00	49,850,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-23,114,500.00	-28,099,500.00
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	112,073,484.17	295,875,383.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-51,689,397.23	-66,144,708.33
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	40,008,242.73	41,408,243.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-30,509,347.95	-34,743,533.33
39300	Биет бус хөрөнгө	1,083,119,798.61	1,501,588,010.98
39301	Програм хангамж	16,385,000.00	16,385,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-3,541,250.00	-8,554,100.02
39303	Бусад биет бус хөрөнгө	1,070,276,048.61	1,493,757,111.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,347,466,255.09	2,063,811,599.87
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	15,391,193.87	16,990,633.45
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15,391,193.87	16,990,633.45
41300	Өглөг	15,391,193.87	16,990,633.45
41360	Бусад өглөг	15,391,193.87	16,990,633.45
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	15,391,193.87	16,990,633.45
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,332,075,061.22	2,046,820,966.42
51	Засгийн газрын хувь оролцоо	1,332,075,061.22	2,046,820,966.42
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	1,078,116,863.00	1,703,870,424.22
51200	Хуримтлагдсан үр дүн	253,002,735.45	341,995,079.43
51210	Өмнөх үеийн үр дүн	175,904,566.11	241,518,198.25
51220	Тайлант үеийн үр дүн	77,098,169.34	100,476,881.18
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	955,462.77	955,462.77
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,347,466,255.09	2,063,811,599.87

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	736,169,900.95	1,129,331,275.11
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	736,169,900.95	1,129,331,275.11
120	Нийтлэг татварын бус орлого	736,169,900.95	1,129,331,275.11
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	8,000,000.00	550,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,000,000.00	550,500.00
120010	Борлуулалтын орлого (Цэвэр) /ТӨҮГ/	728,169,900.95	1,128,780,775.11
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	659,071,731.61	1,028,854,393.93
21	УРСГАЛ ЗАРДАЛ	659,071,731.61	1,028,854,393.93
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	659,071,731.61	1,028,854,393.93
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	659,071,731.61	1,028,854,393.93
210810	Борлуулалт, маркетингийн зардал /ТӨҮГ/	650,505,268.35	1,017,690,296.02
210814	Орлогын татварын зардал /ТӨҮГ/	8,566,463.26	11,164,097.91
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	77,098,169.34	100,476,881.18
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	77,098,169.34	100,476,881.18

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	830,830,863.00	955,462.77	175,904,566.11	1,007,690,891.88
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,078,116,863.00	955,462.77	253,002,735.45	1,332,075,061.22
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	830,830,863.00	955,462.77	175,904,566.11	1,007,690,891.88
7	Өмчид гарсан өөрчилөлт	247,286,000.00	0.00	0.00	247,286,000.00
8	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	77,098,169.34	77,098,169.34
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,078,116,863.00	955,462.77	253,002,735.45	1,332,075,061.22
20	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,703,870,424.22	955,462.77	341,995,079.43	2,046,820,966.42
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,078,116,863.00	955,462.77	241,518,198.25	1,320,590,524.02
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-11,484,537.20	-11,484,537.20
17	Өмчид гарсан өөрчилөлт	625,753,561.22	0.00	0.00	625,753,561.22
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	100,476,881.18	100,476,881.18

### Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант он		Зөрүү
			төлөвлөгөө	гүйцэтгэл	
1	2022 оны шилжих үлдэгдэл	372,889.26	115,578.4	56,350.00	59,228.40
2	Захилагчийн хяналтын орлого	328,291.15	794,853.80	793,232.80	1,621.00
3	Зураг төсвийн орлого	18,429.48	198,487.20	271,293.70	(72,806.50)
4	Зохиогчийн хяналтын орлого	16,752.31	69,755.90	92,556.50	(22,800.60)
	<b>Орлогын дүн</b>	<b>736,362.20</b>	<b>1,178,675.30</b>	<b>1,213,433.00</b>	<b>(34,757.70)</b>
1	Үндсэн цалин	405,686.30	569,951.40	545,582.10	24,369.30
2	Ажил олгогчийн НДШ төлөлт	50,253.00	71,243.93	68,197.76	3,046.17
3	Тэтгэмж урамшуулал	6,670.00	26,000.00	24,151.40	1,848.60
4	Ахмадын сан	4,213.10	1,200.00	911.4	288.60
5	Томилолтын зардал	6,035.20	15,138.00	13,402.00	1,736.00
6	Сургалтын зардал	14,601.60	38,450.00	19,759.10	18,690.90
7	Мэдээлэл, холбооны зардал	3,774.10	4,298.50	3,163.80	1,134.70
8	Даатгалын зардал, АТБӨЯХАТ	702.90	1,200.50	1,200.50	0.00
9	Бичиг хэргийн зардал	7,470.20	9,330.56	9,100.50	230.06
10	Засвар үйлчилгээ, багаж хэрэгслийн зардал	4,633.75	26,845.00	25,480.00	1,365.00
11	Барилга ашиглалтын зардал /ус, дулаан цахилгааны төлбөр/	6,749.39	7,571.70	6,365.60	1,206.10
12	Компьютер, принтерийн сэлбэг хэрэгсэл үйлчилгээний зардал	21,668.60	39,000.00	38,320.00	680.00
13	ХАБЭА-н зардал	18,788.90	24,135.00	23,567.00	568.00
14	Түрээсийн зардал	20,320.80	21,576.00	21,507.50	68.50
15	Шатахууны зардал	10,357.00	21,660.05	19,250.00	2,410.05
16	Маркетингийн зардал	10,492.50	28,492.50	27,524.20	968.30
17	Гадны байгууллагатай хамтарсан арга хэмжээний зардал	10,728.80	121,947.00	83,534.30	38,412.70
18	Шинээр үндсэн хөрөнгө х/а	43,505.40	71,648.90	71,648.90	0.00
19	Авто сэлбэг засвар үйлчилгээ	-			0.00
20	Бусад мөнгөн зардал /дотоод үйл ажиллагааны зардал./	16,788.10	31,880.00	20,859.00	11,021.00
21	Элэгдлийн зардал			31,450.00	-31,450.00
22			0	85,720.54	-85,720.54
	<b>ЗАРДЛЫН ДҮН /мян.төг/</b>	<b>663,439.6</b>	<b>1,131,569.04</b>	<b>1,140,695.60</b>	<b>-9,126.56</b>
	АШИГ+, АЛДАГДАЛ -	72,922.56	47,106.26	72,737.40	-25,631.14
	Татвар 2022	7,292.26	4,710.63	7,273.74	-2,563.11

ТАТВАРЫН ДАРААХ АШИГ, АЛДАГДАЛ /мян,төг/	65,630.30	42,395.63	65,463.66	35,121.89
---	-----------	-----------	-----------	-----------

Аудитаар нийт 416,032.1 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 416,032.1 мянган төгрөгийн алдааг залруулж тайлагналаа. Үүнд:

### **Залруулсан алдаа:**

- Хот байгуулалт, барилга захиалагчийн алба ОНӨААТҮГ нь 2022 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн үндсэн хөрөнгө, бараа материалын оны эхний үлдэгдлийг 17,008.6 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан, мөн орлогын дэлгэрэнгүй тайлан, мөнгөн гүйлгээний тайлангийн өмнөх оны үлдэгдлийг 2023 оны санхүүгийн тайланд тусгаагүй санхүүгийн тайлан гаргасан нь аудитын үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй тул санхүүгийн тайланд залруулав.
- Тайлант онд тушаал шийдвэргүй 399,023.5 мянган төгрөгийн биет бус хөрөнгийг данснаас хассан нь аудитын ангилал, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй тул мөнгөн гүйлгээний тайланд залруулав.

Аудитаар нийт 91,597.7 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, 4,052.6 мянган төгрөгийн зөрчилд 4 төлбөрийн акт тогтоож, 21,447.2 мянган төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага хүргүүлж, 66,097.9 мянган төгрөгийн 6 зөрчилд зөвлөмж өгсөн.

### **5.1 Төлбөрийн акт**

1. Тайлант онд 2 албан хаагчид ээлжийн амралттай байх хугацаанд 1,091.9 мянган төгрөгийн цалинг давхардуулан олгосон, нягтлан бодогч, нярав нарт үндэслэлгүй балансын урамшуулал 2,260.7 мянган төгрөгийг илүү олгосон, тайлант онд арга хэмжээний зардалд 220.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан, албан хаагчдад албан томилолтоор ажилласан хугацаанд хоол, унааны нэмэгдэл 480.0 мянган төгрөгийг давхардуулан олгосонд төлбөрийн акт тогтоов.

### **5.2 Албан шаардлага**

1. Барилгачдын үе үеийн ажилчдын уулзалт хэлэлцүүлгийн 2,970.0 мянган төгрөгийн анхан шатны баримтгүй, ажлын үр дүнгийн тайлан байхгүй зардал гаргасан, 5 албан хаагчийн гадаад нислэгийн зардалд 10,909.5 мянган төгрөгийн зардал гаргасан боловч томилолтоор ажилласан ажлын үр дүнгийн тайлан байхгүй, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, цалингийн зардлаас анхан шатны баримтын бүрдэлгүй 1,800.0 мянган төгрөгийн урамшуулал олгохдоо нийгмийн даатгалын шимтгэл суутгаагүй, 1 албан хаагчид үндэслэлгүй 5,054.7 мянган төгрөгийн орон нутгийн нэмэгдэл, 4 албан хаагчид урамшуулал цалин олгосон, тус байгууллагын нягтлан бодогч нь шаардсан баримт материалыг цаг хугацаанд гаргаж өгөөгүйгээс завсрын аудит хийгдээгүй, аудит хийх нөхцөл боломжоор хангаагүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангаа төсвийн тухай хуулийн цагалбарт хугацаанд ирүүлээгүй зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Тайлант онд гүйцэтгэх удирдлагын тушаал шийдвэргүй, байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд тусгаагүй 59,810.0 мянган төгрөгийн хоол унааны нэмэгдлийг албан хаагчдад олгосон байна.

Энэ нь Компанийн тухай хуулийн 84.4-д "Компанийн эрх бүхий албан тушаалтан нь дараах үүрэгтэй: 84.4.3-д "компанийн эрх ашигт нийцүүлэн үндэслэлтэй шийдвэр гаргах"; 84.6-д "Компанийн эрх бүхий албан тушаалтан нь энэ хуулийн 84.4, 84.5-д заасан үүргээ биелүүлээгүй, удаа дараа зөрчсөнөөс компанид хохирол учруулсан бол учруулсан хохирлыг өөрийн хөрөнгөөр нөхөн төлнө.", Хөдөлмөрийн тухай хуулийн 108.1-д "Ажилтны ур чадварын, ажилласан жилийн, мэргэшлийн зэргийн, хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажилласны болон бусад нэмэгдлийг хууль тогтоомж, хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээгээр тогтооно." Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20.1.4-т "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

**Өгсөн зөвлөмж:** Байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд хоол унааны нэмэгдлийг тусгаж тушаал шийдвэрээр олгож байх.

#### 2. Хөрөнгийн тооллоготой холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Эд хариуцагч солигдох үед хөрөнгө, бараа материалын тооллого хийгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.2-т Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ 12.2.2-т "Эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед" гэж заасантай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Эд хариуцагч солигдох үед хөрөнгө, бараа материалын тооллого хийж байх.

#### 3. Байгууллагын дотоод хяналттай холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Байгууллагын дотоод хяналт шалгалтын нэгжийн ажилтанг томилсон боловч шалгалтын ажлын тусгайлсан төлөвлөгөөг боловсруулаагүй, дотоод хяналт шалгалт хийдээгүй байна.

Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоол 3.4-д "Дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь тухайн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны онцлог, үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэл, хэмжээ, зохион байгуулалтын бүтэц, харьяалагдах нэгж, объектын тоог харгалзан тухайн жилд хийх хяналт шалгалтын ажлын тусгайлсан төлөвлөгөөг боловсруулан эрх бүхий албан тушаалтнаар батлуулан мөрдөж ажиллана", 3.5-д Дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь хяналт шалгалтын ажлын дүн, авсан арга хэмжээний талаар улиралд нэгээс доошгүй удаа тухайн аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагын хурлаар хэлэлцүүлж, шаардлагатай бол шийдвэр гаргуулан хамт олонд мэдээлнэ", 3.6-д "Дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь эрх бүхий албан тушаалтны баталсан удирдамжийн дагуу дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэнэ" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

**Өгсөн зөвлөмж:** Дотоод хяналт шалгалтын комисс нь хяналт шалгалтыг зохион байгуулах журам, ажлын төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллах.

#### **4. Байгууллагын дотоод хяналттай холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** Цагийн бүртгэлээр нотлогдохгүй 4,510.5 мянган төгрөгийн илүү цагийн нэмэгдэл хөлс олгосон байна.

Энэ нь Компанийн тухай хуулийн 84.4-д "Компанийн эрх бүхий албан тушаалтан нь дараах үүрэгтэй: 84.4.3-д "компанийн эрх ашигт нийцүүлэн үндэслэлтэй шийдвэр гаргах;" 84.6-д "Компанийн эрх бүхий албан тушаалтан нь энэ хуулийн 84.4, 84.5-д заасан үүргээ биелүүлээгүй, удаа дараа зөрчсөнөөс компанид хохирол учруулсан бол учруулсан хохирлыг өөрийн хөрөнгөөр нөхөн төлнө.", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтыг аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага хэрэгжүүлнэ", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20.1.4-т "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

**Өгсөн зөвлөмж:** Ажилчдын цагийн бүртгэлийг үнэн зөв хөтөлж, илүү цагийн нэмэгдлийг хуулийн дагуу тухай бүр олгож байх.

#### **5. Зардлын данстай холбоотой асуудал**

**Илрүүлэлт** Жолоочийн тооцооны замын хуудас бичсэн боловч автомашины 100 км-т зарцуулах нормативаар шатахууны тооцоог бодоогүй 618.6 мянган төгрөгийн шатахууныг илүү зарцуулсан, албан хаагчийн хувийн тээврийн хэрэгслээр албан ажил гүйцэтгэн, жолоочийн замын хуудас бичсэн боловч спидометрийн заалтгүй 3,607 километрт 1,158.8 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан байна.

Энэ нь ЗТХСайдын 2019 оны 390 дугаар тушаалын 7 дугаар хавсралтаар баталсан автомашины шатахуун зарцуулалтын нормыг тооцох заавар, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтлөнө", 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

**Өгсөн зөвлөмж:** Автомашины спидометрийн заалтын дагуу шатахууны тооцоог нормативын дагуу бодож байх.

#### **6. Санхүүгийн тайлагналтай холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** Тус компани нь санхүүгийн үйл ажиллагаандаа өөрийн онцлогт тохирсон санхүүгийн тайлан бэлтгэхэд баримтлах нягтлан бодох бүртгэлийн зарчим, горимыг тодорхойлсон "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг батлуулж мөрдөөгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.9-д "нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг" гэж бүртгэлийн суурь, санхүүгийн тайлан гаргахад баримтлах зарчмыг тодорхойлсон журам, заавар, аргачлалыг багтаасан баримт бичгийг", 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана", 20.2-т "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ", 20.2.2-т "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

**Өгсөн зөвлөмж:**

Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар" болон бусад хууль тогтоомжид нийцсэн "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг батлуулж мөрдөх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 06 дугаар сарын 30-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/ сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ХББЗАлба	1	17,008.6			1	17,008.6	1	17,008.6				
	1	399,023.5			1	399,023.5	1	399,023.5				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>416,032.1</b>			<b>2</b>	<b>416,032.1</b>	<b>2</b>	<b>416,032.1</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ХББЗАлба	1	1,091.9	1	1,091.9					2	513.3		
	1	480.0	1	480.0								
	1	2,260.7	1	2,260.7								
	1	220,0	1	220,0								
	1	2,970.0			1	2,970.0						
	1	10,909.5			1	10,909.5						
	1	1,800.0			1	1,800.0						
	1	5,767.7			1	5,767.7						
	1								1	0		
	1	1,777.4							1	1,777.4		
	1	59,810.0							1	59,810.0		
	1								1			
	1								1			
<b>Дүн</b>	<b>15</b>	<b>91,597.7</b>	<b>4</b>	<b>4,052.6</b>	<b>4</b>	<b>21,447.2</b>	<b>6</b>	<b>66,097.9</b>	<b>1</b>	<b>0</b>		

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/сая төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
ХББЗАлба								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>				<b>1</b>		

